

ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2022 оны 4-р сарын 15-ны өдөр

№1

Улаанбаатар хот

Тооллогын дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67.3 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт болон Компанийн дүрэм, 2022 оны 4-р сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй 86.02 хувийн хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн тул тооллогын дүнг хавсралтын дагуу баталж, ээлжит хурлын даргад танилцуулсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



M. Batbold
М.БАТБОЛД

ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН

O. Enkhjargal

О.ЭНХЖАРГАЛ

L. Oyuungerial

Л.ОЮУНГЭРЭЛ



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Тооллогын дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт болон Компанийн дүрэм, 2022 оны 4-р сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь :

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй 86.02 хувийн хувьцаа эзэмшигчид (хавсралт №1) хүрэлцэн ирсэн тул хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцсугай.
2. Хурлын ирц хангалттай тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хурлын дэгийн дагуу явуулахыг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



ХХ

D. Oyuunsuren

Д.ОЮУНСҮРЭН ✓



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20~~22~~²¹ оны ... сарын ...⁰⁴ ~~15~~ өдөр

Дугаар ...⁰²

Улаанбаатар хот

Компанийн 2021 оны санхүүгийн болон
үйл ажиллагааны тайлангийн талаар
дүгнэлт батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 д заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн “Гермес центр” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2022 оны 4-р сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын саналын хуудасны дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь :

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хавсралтын дагуу баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д. Оюунсүрэн

Д.ОЮУНСҮРЭН ✓



ГЕРМЕС ЦЕНТР ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

ТУЗ-ийн төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, 2022 оны 4-р сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын саналын хуудасны дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь :

1. “Гермес центр”ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн төсвийг хавсралтын дагуу баталсугай.
2. Энэхүү батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллахыг ТУЗ-ийн дарга (Д.Оюунсүрэн)-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Д.Туяа)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА   Д.ОЮУНСҮРЭН ✓